

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ТӨРИЙН АУДИТЫН ТАЛААР ТӨРӨӨС
БАРИМТЛАХ БОДЛОГЫН БАРИМТ
БИЧИГ

2018-2026

(Засаж сайжруулсан хувилбар)

ТӨРИЙН АУДИТЫН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО

/2018-2026/

Нэг. Ерөнхий мэдээлэл

1.1 Төрийн аудитын байгууллагын өнөөгийн нөхцөл байдал

- 1.1.1 Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулиар төрийн аудитын тогтолцоо, төрийн аудитын чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, төрийн аудитыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг тодорхойлсон бөгөөд Монгол Улсын Үндэсний аудитын газар нь Монгол Улсын Аудитын дээд байгууллага юм. Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийхээр хуульчлагдсан.
- 1.1.2 Төрийн аудитын тухай хуульд 2013 онд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр орон нутаг дахь Төрийн аудитын байгууллагууд босоо тогтолцоотой болсноор төрийн аудитын нэгдмэл тогтолцоо бүрдсэн билээ.
- 1.1.3 Одоо Төрийн аудитын байгууллага бүх аймгуудад салбар байгууллагатай болж, нийт 389 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байгаа ба 2016 онд санхүүгийн тайлангийн 3297, гүйцэтгэлийн 196, нийцлийн 219, нийтдээ 3712 аудит хийжээ¹.
- 1.1.4 2016 онд аудитаар 16,336.9 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлж, 10.9 тэрбум төгрөгийн акт тогтоож, 1,173.6 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага өгч, 7855 зөвлөмж өгч зөрчил гаргасан 752 албан тушаалтанд хариуцлага тооцуулан, 186 албан тушаалтны асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлжээ.
- 1.1.5 2016 онд улсын хэмжээнд санхүүгийн аудитад хамрагдвал зохих 6296 байгууллагын санхүүгийн тайлангаас 3297-д дүгнэлт гаргаж, аудитад хамрагдвал зохих нийт тайлангийн 52.4 хувь нь аудитад хамрагдсаны 67 хувийг төрийн аудитын байгууллага өөрийн хүний нөөцөөр гүйцэтгэсэн байна.

¹ Төрийн аудитын байгууллагын 2016 оны тайлан

1.1.6 Төсвийн тухай хуулиар Төрийн аудитын байгууллага төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээд, төсвөөс санхүүгийн дэмжлэг авсан төсөл хөтөлбөрийн, нийт 6,5 мянга шахам санхүүгийн тайланд аудит хийж баталгаажуулах үүрэг хүлээдэгийн зэрэгцээ шинээр батлагдаж байгаа хуулиудаар стратегийн ач холбогдол бүхий гол салбаруудын үйл ажиллагаанд жил бүр аудит хийж дүгнэлт гаргаж байх үүрэг хүлээж энэ хэмжээгээр төрийн аудитын байгууллагын ажлын ачаалал нэмэгдэж, санхүүгийн болон хүний нөөцийн хязгаарлагдмал байдал бий болоод байна.

1.2 Төрийн аудитын олон улсын байгууллагын хөгжлийн чиг хандлага

1.2.1 Монгол Улсын Үндэсний аудитын газар нь дэлхийн 191 орны төрийн аудитын дээд байгууллагын гишүүнчлэлтэй Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага (ИНТОСАИ) болон Азийн аудитын дээд байгууллагуудын холбоо (АСОСАИ)-нд 1996 онд гишүүнээр элсэж үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцож ирсэн.

1.2.2 НҮБ-ын Ерөнхий Ассамблейн дээд хэмжээний 70 дугаар чуулганаар дэлхийн улс орнуудын ирэх 15 жилийн хөгжлийн зорилтуудыг тодорхойлсон “Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд аудитын дээд байгууллагын идэвх оролцоог нэмэгдүүлэх замаар сайн засаглалыг дэмжих чиглэлээр боловсруулсан ИНТОСАИ-ын 2017-2022 оны стратеги төлөвлөгөөг баталсан байна.

1.2.3 ИНТОСАИ нь энэхүү стратеги төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх үүднээс гишүүн орнуудын аудитын дээд байгууллагууддаа хандан дээрх стратеги төлөвлөгөөнд үндэслэн хөгжлийн чиг хандлагаа тодорхойлсон стратегийн баримт бичиг боловсруулж мөрдөж ажиллахыг зөвлөж байна. ИНТОСАИ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга нарын газар болон НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн асуудал хариуцсан хэлтэс (DESA) "АДБ, иргэдийн хамтын ажиллагааны үр дүнг бэхжүүлснээр засаглалын олон нийтийн өмнө хариуцлага хүлээх чадварыг дээшлүүлэх" сэдвээр хамтарсан уулзалт зохион байгуулж, энэ талаарх олон улсын туршлага солилцож, цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлов.

1.2.4 АДБ-ууд зөвхөн аудитын тайланг хэвлэн нийтлэхээс өөрөөр иргэдтэй хязгаарлагдмал хүрээнд харилцаа холбоотой байсан бол дээрх уулзалтаар төрийн аудитын байгууллага болон иргэдийн хамтын ажиллагааг хөгжүүлснээр төсвийн хөрөнгө, төрийн байгууллагуудын

үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлж, хариуцлагыг бэхжүүлснээр сайн засаглалыг хөгжүүлэх чиглэлд олон улсын аудитын дээд байгууллагууд анхаарал хандуулах шаардлагатайг онцлон авч үзжээ.

1.2.5 Олон Улсын стандартыг дагаж мөрдөхийн тулд ИНТОСАИ-ийн 9-р чуулганаар 1977 онд баталсан Лимагийн тунхаглалд хараат бус төрийн аудитыг бүрдүүлэхийг уриалж, “Энэ шаардлагыг хангахгүй Төрийн аудитын дээд байгууллага стандартад үл нийцнэ” гэж ИНТОСАИ-н стандартын зарчимд тусгасан байдаг.” гэсэн үнэлгээ өгсөн байна.

1.3 Хэрэгцээ, шаардлага

1.3.1 Монгол Улсын Үндэсний аудитын газрын хүсэлтээр 2010 онд гүйцэтгэлийн аудитын тогтолцоо болон үйл ажиллагаанд Норвеги, Швед Улсын Үндэсний аудитын газрын хамтарсан багаар, 2013 болон 2015 онд Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD) “Монгол Улсын авилгын эсрэг шинэчлэл”-ийн түншийн үнэлгээний хүрээнд “Төрийн санхүүгийн хяналт ба аудит” сэдвээр, 2016 онд санхүүгийн аудитын үр дүнд Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Үндэсний аудитын газрын багаар тус тус түншийн үнэлгээ хийлгэж Монгол Улсын төрийн аудитын дээд байгууллагын үйл ажиллагааны талаар хөндлөнгийн Олон улсын аудитын байгууллагууд үнэлгээ дүгнэлт гаргасан байна.

1.3.2 Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Үндэсний аудитын газрын баг Монгол Улсын Үндэсний аудитын газрын үйл ажиллагаанд түншийн үнэлгээ хийж “Монгол Улсын Үндэсний аудитын газар нь санхүүгийн болон байгууллагын хувьд тодорхой хэмжээний хараат бус байдалтай ч Үндсэн хуулийн заалтгүй нь энэ хараат бус байдалд амархан нөлөөлөх боломжтой²” гэжээ.

1.3.3 Төрийн аудит нь татвар төлөгчдийн хөрөнгийг захиран зарцуулж, шийдвэр гаргаж буй төрийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд аудит хийж, дүгнэлт гарган, иргэдийг бодит мэдээллээр хангах, төрийн байгууллага төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй, үр нөлөөтэй зарцуулахад нь зөвлөн дэмждэг байх шаардлага тавигдаж байна.

² ИНТОСАИ-ийн Аудитын дээд байгууллагын гүйцэтгэлийн хэмжүүрийн үзэл баримтлалыг ашиглан Монгол Улсын Үндэсний Аудитын Газрын санхүүгийн аудит болон бусад үйл ажиллагаанд хийсэн олон улсын түншийн үнэлгээний багийн тайлан, 2016 оны 12-р сар

1.4 Бодлого боловсруулах үндэслэл

- 1.4.1 Төрийн аудитын хууль, эрх зүйн орчин тодорхой хэмжээгээр бүрдсэн ч төрийн аудитын талаар төрөөс баримтлах нэгдсэн бодлого тодорхойлогдоогүй байгаа нь төрийн аудитын үйл ажиллагааны нэгдмэл байдал хангагдахгүй, хөгжлийн бодлого, чиглэл тодорхойгүй байхад нөлөөлж байна.
- 1.4.2 Мөн түүнчлэн Засгийн газрын дотоод аудит, хараат бус аудитын компаниуд болон төрийн аудитын үйл ажиллагааны зохистой нэгдмэл байдлыг төрийн бодлогоор хангах, харилцан уялдаатай ажиллах нэгдсэн бодлого үгүйлэгдэж байгаа юм.
- 1.4.3 Төрийн аудитын нийгэмд оруулах үнэ цэнэ ба өгөөж, улс орны хөгжилд үзүүлэх бодит нөлөө, Олон Улсын аудитын байгууллагын хөгжлийн чиг хандлагыг харгалзан үзэж, улс орны тогтвортой хөгжилд гүйцэтгэх үүрэг нь өсөн нэмэгдэж байгаа өнөөгийн нөхцөлд төрийн аудитыг цаашид хөгжүүлэх бодлогыг тодорхойлох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.
- 1.4.4 Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйл, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.3.1 дэх заалт, “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын тогтвортой хөгжлийн засаглалын зорилт 1, 2 болон 4, Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийн 1.1 дэх заалт, Авилгатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийн 4.1.3.2, 4.1.3.9 болон 4.1.3.10 заалтууд нь төрийн аудитын талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулах үндэслэл болно.
- 1.4.5 Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд Монгол Улсын хөгжлийн чиг хандлагыг 2030 он хүртэл тодорхойлсон бөгөөд хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавьж, хариуцлагатай, чадварлаг засаглалыг бэхжүүлэхэд төрийн аудитын салбарын хувь нэмэр өндөр байгаа нь тус салбарын хөгжлийн бодлогын зорилт, зорилгыг тодорхойлох хэрэгцээ шаардлагыг бий болгож байна.
- 1.4.6 Төрийн бүх шатны байгууллагын удирдлагын манлайллыг дээшлүүлж, иргэдийн оролцоо, төр хувийн хэвшлийн түншлэлийг хангасан ил тод хариуцлагатай засаглалыг бүрдүүлэхэд төрийн аудитын салбар ихээхэн үүрэгтэйг Аудитын дээд байгууллагуудын Олон Улсын

байгууллага 2017-2022 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөндөө тодорхойлжээ.

1.3 Бодлогын хамрах хүрээ

1.3.1 Төрийн аудитын талаар төрөөс баримтлах бодлогыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх бөгөөд хамрах хүрээг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- 1.3.1.1. бүх шатны төрийн байгууллага;
- 1.3.1.2. төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд;
- 1.3.1.3. орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд;
- 1.3.1.4. хараат бус аудитын компаниуд;
- 1.3.1.5. иргэний нийгмийн байгууллага болон төрийн бус байгууллага;
- 1.3.1.6. иргэд;

1.4 Бодлогыг хэрэгжүүлэх зарчим

1.4.1 “Төрийн аудит бол улс орны тогтвортой хөгжлийн тулгуур хүчин зүйл” гэж үзэж төрийн аудитаас нийгэмд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын төрөөс төрийн аудитыг бодлогоор дэмжиж, дараах зарчимд тулгуурлан хэрэгжүүлнэ. Үүнд:

- 1.4.1.4 хууль дээдлэх;
- 1.4.1.5 шударга ёсыг хангах,
- 1.4.1.6 ил тод бодитой байх,
- 1.4.1.7 төрийн аудитын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандартад нийцсэн байна.

Хоёр. Бодлогын зорилго, зорилт

2.1 Бодлогын зорилго

2.1.1 Төрийн аудитын талаар төрөөс баримтлах бодлогын зорилго нь төрийн аудитын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгож, хараат бус байдлыг баталгаажуулах, төрийн аудитын хөгжлийг Олон Улсын чиг хандлагад нийцүүлэн, мэргэшсэн, чадварлаг хүний нөөц бүрдүүлэх, гадны харилцагч талуудтай үр дүнтэй харилцах замаар сайн засаглалыг дэмжиж, нийгмийн хөгжилд бодит хувь нэмэр оруулахад оршино.

2.2 Бодлогын зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

2.2.1 Төрийн аудитын удирдлагын манлайллыг бүх шатанд дээшлүүлж, иргэд олон нийтийн оролцоо, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангасан, ил тод, хариуцлагатай засаглалыг төрийн аудитын төв, орон нутгийн түвшинд бүрдүүлэх зорилгын хүрээнд :

2.2.1.1 **Зорилт 1.** Төрийн аудитын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх механизмыг бий болгоно.

2.2.1.2 **Зорилт 2.** Төрийн аудитын удирдлагын манлайллыг дээшлүүлж, гадны харилцагч талуудтай харилцах харилцааг хөгжүүлнэ.

2.2.1.3 **Зорилт 3.** Төрийн байгууллагын үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлж, төрийн байгууллагад итгэх олон түмний итгэлийг дээшлүүлэхэд бодитой дэмжлэг үзүүлнэ.

2.2.2 Хүний нөөцийг хөгжүүлж, дэвшилтэт технологи нэвтрүүлэх замаар аудитын үйл ажиллагааг чанаржуулж, олон нийтийг үнэн зөв мэдээллээр ханган, төрийн аудитын хараат бус, хариуцлагатай, хүмүүнлэг, чадварлаг бүтцийг бэхжүүлэх зорилгын хүрээнд:

2.2.2.1 **Зорилт 1.** Төрийн аудитын хөгжлийн шаардлагыг хангахуйц мэдлэг, чадвар бүхий хүний нөөц бүрдүүлж, хариуцлагатай, чадварлаг бүтцийг бий болгоно.

2.2.2.2 **Зорилт 2.** Төрийн аудитад орчин үеийн дэвшилтэт технологи нэвтрүүлж, төрийн аудитын мэдээллийн системийг бий болгоно.

2.2.2.3 **Зорилт 3.** Төрийн аудитын хараат бус байдлыг баталгаажуулан, хууль, эрх зүйн орчныг сайжруулах замаар хөгжлийн таатай орчинг бүрдүүлнэ.

Гурав. Бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1 Төрийн аудитын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх механизмыг бий болгох зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.1.1 Төрийн аудитын үйл ажиллагаанд иргэдтэй ажиллах тогтолцоо бий болгож, иргэдийн оролцоог хангах хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

3.1.2 Иргэд, төрийн аудитын байгууллага хоорондын хамтын ажиллагааг зохицуулсан механизмыг бий болгож, үйл ажиллагааг нь төлөвшүүлнэ.

- 3.1.3 Төрийн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийг олон нийтэд ил тод мэдээлэх тогтолцоог боловсронгуй болгож, төрийн байгууллагын үйл ажиллагаа, түүний үр дүнг нээлттэй болгоход дэмжлэг үзүүлнэ.
- 3.2 Төрийн аудитын гадны харилцагч талуудтай харилцах харилцааг хөгжүүлэх зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:
 - 3.2.1 Төрийн аудитын гадны харилцагч талуудтай харилцах харилцааг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж, үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
 - 3.2.2 Харилцагч талууд болон тэдний сонирхлыг тодорхойлсон судалгаа мэдээллийн санг бий болгож, харилцагчтай харилцах тогтолцоог бүрдүүлнэ.
 - 3.2.3 Хэрэглэгчдийн хүсэн хүлээсэн аудитыг найдвартай, чанартай гүйцэтгэх, мэргэжлийн стандарт, эрхэмлэх үнэт зүйлсийг баримталж ажиллахад нөлөөлөхүйц аудитын арга зүй, үйл явц, журам, аргачлалыг боловсронгуй болгож, тасралтгүй хэрэгжүүлэх тогтолцоог төлөвшүүлнэ.
- 3.3 Төрийн байгууллагын үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлж, төрийн байгууллагад итгэх олон түмний итгэлийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:
 - 3.3.1 Төрийн байгууллагуудын төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй зарцуулахад нь зөвлөн дэмждэг байгууллага байхад үйл ажиллагаагаа чиглүүлнэ.
 - 3.3.2 Аудитын зөвлөмжийн мөрөөр арга хэмжээ авч, зөрчлийг арилгуулах, бууруулах үр дүнтэй механизмыг бий болгож, зөвлөмжийн хэрэгжилтийн үр нөлөөг сайжруулна.
 - 3.3.3 Төрийн аудитын үйл ажиллагаа чанартай, үр нөлөөтэй хэрэгжихэд холбогдох стандарт, гарын авлага, арга зүй, арга хэрэгслийг зохих ёсоор бүрдүүлж, чанарын удирдлагын тогтолцоог хөгжүүлнэ.
- 3.4 Төрийн аудитын хөгжлийн шаардлагыг хангахуйц мэдлэг, чадвар бүхий хүний нөөцийг бүрдүүлж, хариуцлагатай, чадварлаг бүтцийг бий болгох зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:
 - 3.4.1 Төрийн аудитын мэргэжилтэй ажилтныг өндөр хөгжилтэй улс оронд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сургалтын байгууллагад бэлтгэж, Хүний нөөцийн чадамжийн хүрээ (Human Resources Competence Framework)-г бий болгоно.

- 3.4.2 Мэргэжилтэй хүний нөөцийг олон улсын стандарт, шаардлага, өөрийн орны онцлог, эрх зүйн орчинд нийцүүлэн сургаж, дадлагажуулж, гэрчилгээжүүлэх нэгдсэн тогтолцоог бүрдүүлнэ.
- 3.4.3 Төрийн аудитын мэргэшсэн ажилтнуудын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор гүйцэтгэлийн үнэлгээнд тулгуурласан цалин хөлс, урамшуулал болон нийгмийн асуудлыг шийдвэрлэх механизмыг хэрэгжүүлнэ.
- 3.4.4 Дотоодын сургалтын байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, олон улсын стандартад нийцсэн төрийн аудитын мэргэжлийн сургалт явуулна.
- 3.5 Төрийн аудитад орчин үеийн дэвшилтэт технологи нэвтрүүлж, төрийн аудитын мэдээллийн системийг бий болгох зорилтод хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:
 - 3.5.1 Төрийн аудитын судалгаа, мэдээллийн системийг бий болгож, хөгжүүлэн, төрийн аудитын мэдээллийн аюулгүй байдлыг хангана.
 - 3.5.2 Төрөлжсөн аудит тус бүрийн төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах үйл явцад дэвшилтэт технологи нэвтрүүлж, программд суурилсан аудитын арга зүй, аргачлалыг хөгжүүлнэ.
 - 3.5.3 Төрийн аудитын үйлчилгээний шинэ тогтолцоо болох “Цахим аудит” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 3.6 Төрийн аудитын хараат бус байдлыг баталгаажуулан, хууль, эрх зүйн орчныг сайжруулах замаар хөгжлийн таатай орчинг бий болгох зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:
 - 3.6.1 Аудитын үндсэн зарчмуудын талаарх Лимагийн тунхаглалд заасан нөхцөлийг хангана.
 - 3.6.2 Олон Улсын аудитын дээд байгууллагуудын хөгжлийн чиг хандлага, бодлогод нийцүүлэн Төрийн аудитын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, батлуулах, үүнтэй уялдуулан төрийн аудитын үйл ажиллагаатай холбогдох бусад хуулийн заалтуудыг боловсронгуй болгоно.
 - 3.6.3 Төрийн байгууллагууд, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд төсвийн хөрөнгийг үр дүнтэй, хуулийн дагуу захиран зарцуулж буйд хяналт тавих талаар холбогдох хуульд шинээр заалт оруулна.

Дөрөв. Төрийн аудитын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үе шат

4.1 Төрийн аудитын талаар төрөөс баримтлах бодлогыг дунд хугацааны болон урт хугацааны 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

4.1.1 Дунд хугацааны буюу 2018-2022 он: Энэ үе шатанд төрийн аудитын хангах хууль эрх зүйн орчинг бүрдүүлж, иргэдийн оролцоотой хараат бус байдлыг баталгаажуулах зохицуулалтыг бий болгох замаар нийгэмд хувь нэмэр болох боломжийг бүрдүүлнэ.

4.1.2 Урт хугацааны буюу 2022-2026 он: Энэ үе шатанд төрийн аудитын хөгжлийг олон улсын чиг хандлагад нийцүүлэх, төрийн аудитын хөгжлийн шаардлагыг хангахуйц хүний нөөцийг бүрдүүлэх, харилцагч талуудтай үр нөлөөтэй харилцах замаар сайн засаглалыг дэмжиж, нийгэмд оруулах үр нөлөөг нэмэгдүүлнэ.

Тав. Бодлогын үр нөлөө, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн

Бодлогын үр нөлөө

5.1 Төрийн аудитын талаар төрөөс баримтлах бодлогыг баталж хэрэгжүүлснээр төрийн аудитын хөгжлийг олон улсын чиг хандлагад нийцүүлэх, төрийн байгууллагуудын үйл ажиллагааг зөв зохистой чиглэлд оруулах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг бодит үр дүн гарах юм.

Шалгуур үзүүлэлт

5.2 Бодлогын зорилтын хэрэгжилтийг 2016 оны түвшин, үзүүлэлттэй харьцуулах ба хүрэх үр дүнг АДБОУС, ИНТОСАИ-ийн гүйцэтгэлийн хэмжүүрийн үзэл баримтлалийн шалгуур үзүүлэлтийн дагуу үе шат тус бүрээр хэмжинэ.

Үр дүн

5.3 Төрийн аудитын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

5.3.1 Төрийн аудитын байгууллага нь хүмүүнлэг, иргэний байгууллага болж, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны зорилтуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

5.3.2 Төрийн салбарт үйл ажиллагааны стандарт бий болж, төрийн байгууллагуудын тогтолцооны алдаа дутагдлыг тодорхойлж, зөвлөн тусалдаг төрийн институци бий болно.

5.3.3 Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны чанар, үр дүн дээшилж, эдийн засаг, нийгмийн салбаруудын хөгжилд оруулах хувь нэмэр өснө.

5.3.4 Төрийн аудит, Засгийн газрын дотоод аудит, хараат бус аудитын компаниудын харилцан ажиллагаа сайжирч, улсын хэмжээнд аудитын үйл ажиллагааны нэгдмэл, зохистой бодлого бий болно.

Зургаа. Шаардагдах хөрөнгө, санхүүжилтийн эх үүсвэр

6.1 Төрийн аудитын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгана.

6.2 Төрийн аудитын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ. Үүнд:

6.2.1 Улсын болон орон нутгийн төсөв;

6.2.2 Гадаадын хандив, зээл, тусламж;

6.2.3 Улсын Их Хурлаас хуульчлан баталсан бусад эх үүсвэр.

Долоо. Бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

7.1 Төрийн аудитын байгууллага бодлогын хэрэгжилтэд хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дөрвөн жил тутамд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулна.

7.2 Төрийн аудитын байгууллага бодлогын хэрэгжилтийг удирдан зохион байгуулах ба бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнгийн тайланг олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлж, хэлэлцүүлнэ.